



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Холбогдох арга хэмжээ авах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 31.3, “Азиа пасифик пропертис” ХК-д хийсэн шалгалтын тайланг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Азиа пасифик пропертис” ХК-ийн 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тул хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг 2012 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэж, Хороонд мэдэгдэхийг “Азиа пасифик пропертис” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Ли Майкл Кашелл/-д үүрэг болгосугай.

2. “Азиа пасифик пропертис” ХК-д үүрэг өгсөнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай:

1/ Энэхүү тогтоолын 1-д заасан үүргийг бүрэн хэрэгжүүлж дуустал “Азиа пасифик пропертис” ХК-ийн үнэт цаасны арилжааг үргэлжлүүлэн зогсоох арга хэмжээ авах;

2/ Шалгалтаар илэрсэн “Ситико аудит” ХХК-ийн гарсан зөрчил дутагдалын талаар санхүүгийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх;

3/ Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийгэд мэдээлж ажиллах.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001497